



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр, Баасан гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-16</i>
<hr/>	
<i>1. “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>5-16</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 01 дүгээр сарын 12-ны өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, Т.Доржханд, Л.Оюун-Эрдэнэ, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар, Ж.Эрдэнэбат.

**Нэг. “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, референт О.Дөлгөөнтуул, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Н.Энхболд:** “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5

Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.** “Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан боловсруулсан/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, референт О.Дөлгөөнтуул, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Н.Энхболд:** “Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 45 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр 10 цаг 10 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин  
Д.Сүхбаатар” танхим 09 цаг 25 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Н.Энхболд:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Ирц бүрдсэн байна ТББХ-ны 2024 оны 1 сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Хуралдаанд Ганболд гишүүн, Амарсайхан гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Жаргалмаа гишүүн, Энхболд, Батсуурь, Занданишатар, Пүрэвдорж, Бямбацогт, Сарангэрэл нар хүрэлцэн ирсэн байна. Ингээд ирц бүрдсэн байна. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Өнөөдөр 2 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн.

Төрийн байгууллагуудыг бүсчлэн байрлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Энэ Засгийн газраас өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл байгаа.

Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Үүнийг Байнгын хорооноос санаачилж байгаа. Ийм 2 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай хүн байна уу? Алга байна.

Ингээд асуудлаа хэлэлцэж эхэлье. Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд Дэлгэрсайхан танилцуулна.

2024 оны 1 сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн ийм төсөл байгаа.

**Б.Дэлгэрсайхан:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан шинэ сэргэлтийн бодлогод шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд ААН-үүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах зорилтыг тусгасан. Түүнчлэн Улсын Их Хурлаас Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан боловч төрийн байгууллагууд нийслэл Улаанбаатар хотод төвлөрсөн, хүн амын тоо жил бүр тогтмол өсөж байгаа зэргээс шалтгаалан уг үзэл баримтлалд дурдсан хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах асуудал гажуудсан байна.

Иймд хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт төвлөрлийг сааруулах шийдэл нь олон улсын жишигийн дагуу бүсчилсэн хөгжлийг дэмжин хүн амын шилжилт хөдөлгөөнийг татах бодитой хүчин зүйлсийг бий болгож, нийслэл хотыг чиглэсэн эрчимтэй хотжилтын үйл явцыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Тогтоолын төслийг хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж, хөгжлийн түвшнийг ойртуулах, бүсүүдийн хөгжлийн түвшнийг эрэмбэ дараатай дээшлүүлэх орон нутгийн хөгжлийг дэмжих Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор боловсруулж дараах асуудлыг тусгалаа.

Үүнд:

1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн төрийн байгууллагуудын эрхлэх асуудал,

чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг харгалзан бүсчлэн нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн байршуулах арга хэмжээ авах.

2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ажиллах төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгааг хангах асуудлыг судалж зохих арга хэмжээ авах шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж санал боловсруулж шийдвэрлүүлэх.

3. Төрийн байгууллага түүнчлэн албан хаагчдыг орон нутагт бүсчилсэн байдлаар шилжүүлэн байршуулахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр тооцон тухайн жилийн улсын төсвийн төсөлд тусган шийдвэрлэж байх талаар холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгах асуудал болон тогтоолын хэрэгсэлд хяналт тавих тухай зохицуулалтыг тусгасан болно.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Дэлгэрсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын дарга Дондогмаа мөн Хэрэг эрхлэх газрын референт Дөлгөөнтуул байж байна. Эдийн засаг хөгжлийн яамны Бүс нутаг аж ахуй үйлдвэрийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр гэсэн ийм хүмүүс хуралдаанд оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад асуух асуулттай хүн байна уу. Засгийн газрын гишүүд өөрснөө

Засгийн газраас юм оруулчаад өөрснөө асууж, цаг аваад байх юм. Ер нь энэ зарчмаа хэдүүлээ цаашидаа Занданишатар дарга аа, Их Хурал дээр ч, Байнгын хороон дээр ч гарч анхаарахгүй бол Засгийн газрын гишүүд орж ирээд л юм асуух барих нь ч яах вэ. Бие, биеийнхээ байр суурийг илэрхийлэхгүй эсэргүүцээд, нэг кабинетын гишүүд биш юм шиг. Ийм зарчимгүй байдал сүүлийн үед нэлээн газар авах гээд байна шүү. Бямбацогт сайд.

**С.Бямбацогт:** Би Их Хурлын гишүүн. Тэгээд Их Хурлын гишүүнийхээ эрхийг эдэлнэ. Хэнээр ч заалгахгүй, хэнээр ч хэлүүлэхгүй. Их Хурлын гишүүний эрх байгаа шүү надад. Бас мэдээж Засгийн газраас өргөн барьсан тогтоол, Засгийн газраас өргөн барьсан хууль дүрэм үүнийг кабинетын зарчмаар ажиллах ёстой Энхболд даргын бас хэлж байгаа Засгийн газрын бас өргөн барьсан хууль тогтоол дээр бие биеэ дэмжих, Засгийн газрынхаа байр суурийг дэмжих, хамгаалах үүрэгтэй. Үүнийгээ бас хэрэгжүүлэхгүй байгаа талаар Энхболд даргын хэлж байгааатай санал нэг байгаа. Их Хурлын гишүүнийхээ хувьд энэ бүсчилсэн хөгжлийн асуудлыг олон жил ярьсан. 2008 онд Их Хурлын гишүүн болсон цагаасаа эхлээд алслагдсан бүс нутгийн нэмэгдэл, энэ Улаанбаатар хотоос алслагдах тусмаа ард иргэдийн амьдрал хүндэрдэг. Бараа бүтээгдэхүүн үнэ нь өсдөг, зардал нь нэмэгддэг, орлого нь буурдаг. Үүнийг шийдэх ёстой гэж олон жил ярьсан, тодорхой асуудлуудыг ч шийдсэн ингээд явж байгаа.

Өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас энэ төрийн байгууллагыг бүсчлэн байгуулах, Монгол Улсын Их Хурлаас бүсчилсэн хөгжлийн тогтоол батлах ийм асуудлууд орж ирж байгааг дэмжиж байгаа. Бүх бололцоогоор дэмжиж байгаа. Яагаад гэвэл олон жил ярьсан учраас. Олон жил ярьж байж 2017 онд бид нар энэ ялгавартай татварын тогтолцоог бий болгосон. Улаанбаатараас 500- 1000 км алслагдсан

бол 5 хувийн татвартай, 1000-аас дээш алслагдсан бүс нутагтаа 1 хувийн татвартай, Улаанбаатарт 10 хувийн татвартай. Өөрөөр хэлбэл 10 дахин бага татвар авах бололцоо боломжтой болсон байгаа. Ийм байдлаар үндсэндээ хөнгөлөлтөөр алслагдсан бүс нутгийг дэмжих энэ Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах. Яагаад ганцхан Улаанбаатар гэсэн ганцхан таталцлын төвтэй болчихоод Улаанбаатартаа бүгд шаваад байгаа юм. Улаанбаатарт орлого олж болдог, Улаанбаатарт зарлага багатай амьдарч болдог. Ийм учраас ард иргэд аятай тухтай амьдралын эрхээр Улаанбаатар руу шаваад байгаа юм. Үүнийг шийдэхийн тулд бид нар тэр Монгол улсдаа баруун, зүүн, өмнөд, хойд, хаана л бол таталцлын төвүүдийг бий болгож Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах ийм бодлого хэрэгжүүлэх ёстой гэж бодож байгаа юм.

Тэгээд төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тал дээр ч манай Зам, тээврийн хөгжлийн яам бас манлайлж ажиллана. Тавантолгой төмөр замыг Тавантолгой орд дээр нь байршуулах, Монголын төмөр замыг Сайншанд руу нүүлгэх мөн бас Улаанбаатар хотод түгжрээд байгаа, Улаанбаатараас Буянт-Ухаа руу иргэний нисэхийн ерөнхий газрынхан, МИАТ-ийнхэн гээд 3 мянга орчим албан хаагч өглөө болгон ажилдаа явдаг орой болгон түгжрэлд наашаа ирдэг. Үүнийг шийдэх гэж бид нар бас тээвэрчин хотхон Буянт-Ухаад барьж байгаа. Тэнд нийт ажилтан албан хаагчдынхаа орон сууцыг барья. Тэнд нийт салбарынхаа ажилтан албан хаагчдын оффис ажлын байрыг бий болгоё. Мөн түүнийг дагуулаад сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, худалдаа үйлчилгээ спорт заал бүхий л юм нэг дороо.

Ерөөсөө л иргэн тэнд ажиллах, амьдрах, амрах орчин нэг дор зохицуулахаар явж байгаа. Харамсалтай нь энэ тогтоол маань дэмжигдэхгүй их удаан яваад байна. Төрийн өмчийн хороон

дээр, Нийслэл дээр бусад байгууллагууд дээр ингээд л. Тэнд манай хот, хөдөөгийн хөгжлийг хариуцсан, Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрлийг сааруулах ажлыг хариуцсан манай Дэлгэрсайхан сайд бас анхааралдаа авч өгөөч. 7 сараас хойш би энэ тээвэрчин хотхон байгуулах асуудлыг энэ төрийн албан хаагч нарын хүнд суртал гарын үсгийг хүлээгээд л ингээд удаашираад явж байгаа. Үүнийг та бас нэг эрчимжүүлэх тал дээр бас анхааралдаа авч өгөөч ээ.

Их Хурлын гишүүн, сайд ингээд анхаараад явж байхад л ийм удаан явж байгаа юм чинь бусад хүмүүсийн ажил яаж явдаг байгаа нь ойлгомжтой шүү дээ. Ийм байдалтай байгаа. Тэгээд тээвэрчин хотхон гээд хот дээр тодорхой асуудлууд гарын үсэг хүлээгдэж байна, Төрийн өмчийн хороон дээр хүлээгдэж байна. Энэ бүхэн дээр та бас нэг анхааралдаа аваад өгөөч гэж танаас хүсэх гэж байна.

**Н.Энхболд:** Бямбацогт сайд үг хэллээ. Ганболд гишүүн.

**Г.Ганболд:** Бүсчилсэн хөгжлийг дахиж ярих нь зөв өө. Бид нар олон жил Бүсчилсэн хөгжил гээд үндэсний хороо байгуулаад энэ чинь ажлын албатай хүртэл байсан юм. Би бас хангайн бүсийн зөвлөлийн даргаар ажиллаж байсан хүн л дээ. Тэгээд өмнөх бүсчлэл нь ерөөсөө эдийн засгийн хувьд бүсчлээгүй, газар нутгийнх нь хувьд бүсчилсэн байсан учраас хамгийн дээд талын хийж байсан ажил нь нэг бүсийн үзэсгэлэн худалдаа хийгээд тэгээд уралдаан тэмцээнээс хэтрээгүй.

Одоо ингээд өргөн хэмжээний хэлэлцүүлэг хийх нь бүсчилсэн хөгжлөөр. Миний энэ тогтоолоос ойлгож байгаагаар 1 сарын 25-ны дотор Засгийн газраас бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар тайлан лавлагаа, мэдээлэл бэлдэж өгөх юм байна гэж ингэж ойлголоо. Тэгэхээр



бид нар очоод хэлэлцүүлэг хийхэд шууд ингээд задгай хэлэлцэх үү эсвэл Засгийн газраас юм уу, өмнө нь бэлдсэн загварчлал юм уу, эдийн засгийн бүсчлэлийг нэг юм тойрч ярихгүй бол энэ чинь задгай ярих юм бол хамаагүй юм болно шүү дээ. Энэ чинь юу хамаагүй гарч ирнэ. Тэгэхээр зэрэг өмнөх байсан 5 бүсээ энэ хэмжээнд нь ярих юм уу эсвэл сая Их Хурлын томсгосон тойргоор энэ чинь хөдөө орон нутагт чинь 6, Улаанбаатараас гадна 6 бүс нийтдээ 7 бүс болчихлоо. Энэ Их Хурлын тойрог чинь өөрөө бүсийн ингээд үзэл баримтлал болох юм уу. Тэгээд үүнийг бид нар хөдөө орон нутагт очоод энэ эдийн засгийн форум хийхэд, орон нутагт очоод хэлэлцүүлэг өрнүүлэхэд 2 төрлийн ч юм уу нэг загварчлалтай байж, байж тэгж ярихгүй бол ингээд өмнө нь бас энэ хэлэлцүүлгүүд их олон болж байсан юм. Одоо энэ Тогтох гуай нар хүртэл орон нутгаар, бүх аймгуудаар хэлэлцүүлэг хийгээд энэ бүсийн юунууд зөндөө явж байсан. Тэгэхээр үүнийг хамгийн боломжит хувилбаруудаар юм уу ингэж явуулах ийм боломж байгаа юу? Яг яаж хэлэлцүүлэг өрнүүлэх гэж байна. Тэгээд би энэ тогтоолоос ямар ч гэсэн ингээд нэлээн өргөн хэмжээний хэлэлцүүлгүүд өрнөх юм байна. Тэгээд эндээс гарсан шийдвэрийг нь Төрийн байгуулалтын байнгын хороо 3 сард багтаагаад гарсан саналыг нь Их Хуралд танилцуулах ийм тогтоолын төсөл юм байна л гэж ингэж ойлгож байна. Тэгэхээр би Хэрэг эрхлэх газрынхнаас энэ талаар тодорхой мэдээлэл авъя.

**Н.Энхболд:** Би нэг юм түрүүлээд хэлчихье. Өнөөдөр бид нар 2 асуудал хэлэлцэж байгаа. Хоорондоо яг уялдаатай. Сая Ганболд гишүүний асуусан Төрийн байгуулалтын байнгын хорооноос санаачилж байгаа 2 дахь тогтоолтой холбоотой юмнууд байна. Тэгээд тэнд дахиад дэлгэрэнгүй ярьчихъя. Ганбат дарга ямар ч байсан өөрсдийнхөө бэлдсэн хэмжээнд хариулт өгчих.

**Д.Ганбат:** Улсын Их Хурлын гишүүдэд энэ өглөөний мэнд хүргэе.

Ганболд гишүүний асуултад хариулъя. Тэгээд энэ төрийн байгууллагуудыг бүсчилсэн байдлаар байршуулах энэ тогтоолын төсөл дээр ерөнхий таны саяын хэлдэг тэр чиглэлүүдийн хүрээнд бид тодорхой арга хэмжээ авахаар Их Хурлаасаа бас ийм тогтоол гаргаж өгөөч гэж хүсэж оруулж ирж байгаа. Энэ тогтоолын хүрээнд Засгийн газрын хэмжээнд улсын хэмжээгээр тооцоод тэгээд ямар бүсчилсэн нутаг дэвсгэрийн хэмжээ байх вэ? Тэр юунуудаа гаргаад ингээд төлөвлөлтийн маш том өргөн үйл ажиллагаа явагдана. Өөрөөр хэлбэл төрийн бүх шатны ялангуяа Засгийн газрын үндсэн бүрэлдэхүүнд ордог энэ яам, тамгын газруудын эрхэлж байгаа үйл ажиллагаа, үйл ажиллагааны цар хүрээ, чиглэл, байршил энэ бүх нөхцөл байдлыг бас харгалзаж үзнэ. Мэдээж таны саяын хэлдэгтэй яг нийцтэй байгаа. Тэр нь юу юм бэ гэхээр бүсчилсэн байдлаар хөгжлийн бодлогын төлөвлөлтийг төлөвлөх энэ үйл ажиллагааг нэлээн өргөн далайцтай хэрэгжүүлнэ. Ийм арга хэмжээгээ авах юм. Энэ дээр өмнө нь бүсчилсэн байдлаар бүс нутгийн асуудлыг нэлээн өргөн хүрээнд авч үзэж байсан. Яг өнөөдөр эрх зүйн байдлынхаа хувьд бүсийн асуудлыг зохицуулж байгаа хууль байна. Их Хурлын бас өмнө нь гарсан тогтоол шийдвэрүүд байгаа. Тэгэхээр яг энэ тодорхой бүсчлэх асуудлаар манай Эдийн засаг хөгжлийн яамны асуудал хариуцсан газрын дарга маань орж байгаа. Тодорхой хариултыг танд өгнө. Бид Засаг дээр эхний ээлжид Их Хурлын тогтоолоо гаргаж аваад, үүнийхээ хүрээнд нэлээн өргөн төлөвлөлтийн асуудлыг шат дараалсан байдлаар авахаар ингээд төлөвлөж байгаа.

**Н.Энхболд:** Чи 2 дахь тогтоол дээр илүү дэлгэрэнгүй Ганболд гишүүний асуултад хариулаадхаарай. Ганболд гишүүн.

**Г.Ганболд:** Эхнийх дээр би энэ хэлэлцэхэд их төвөгтэй юм аа, эхнийх нь. Одоо яг хааш нь юуг гаргах юм. Тийм

төсөөлөл юм байгаа юм уу. Тэгэхгүй эхнийх нь их төвөгтэй юм байна шүү дээ, хэлэлцэхэд. Ер нь цаашидаа яг энэ тогтоолын төслийн агуулгаас харахад яам, тамгын газар, энэ төрийн байгууллагуудыг ер нь үе шаттайгаар Улаанбаатар хотоос нүүлгэе гээд. Улаанбаатар хотоос яг нүүнэ гэхээр ер нь Засгийн газар мэдээж энэ төсөөлж л оруулж ирсэн байх даа. Жишээлбэл, хаашаа нүүх юм. Жишээлбэл хамгийн түрүүнд Засгийн газрын төсөөллөөр яг ямар яам аль бүс рүү Улаанбаатараас гараад яг хаашаа нүүх юм бэ. Энэ дээр нэг жишээ хэлээдхээч. Яг Хэрэг эрхлэх газар дээр оруулж ирэхдээ.

**Н.Энхболд:** Ганбат дарга. 4 номер.

**Д.Ганбат:** Засгийн газрын хуралдаанд танилцуулагдсан яг энэ бүс нутгийн хөгжлийн асуудлыг бүсчилсэн байдлаар төлөвлөлт хийх энэ асуудлын хүрээнд нэлээн тийм тойм загвар урьдчилсан маягаар хийгдсэн юм байгаа Ганболд гишүүн ээ. Үүнийг Их Хурлын гишүүддээ бид өнөөдрийн энэ тогтоол хэлэлцүүлсний дараа бичгээр хүргүүлэе. Албан ажлын журмаар ч гэсэн өгчихье. Ер нь нэг тойм судалгаа загвар тэгээд урьдчилсан байдлаар хийчихсэн ийм төлөвлөлтийн үйл ажиллагаа байгаа. Хангалттай хэмжээний мэдээллийг агуулсан. Энэ дээрээ үндэслээд тэгээд өмнөх бүсчлээд хуваасан тэр хэлбэрээрээ явах юм уу, сүүлийн Их Хурлын сонгуультай холбогдуулаад энэ бүсчилсэн энэ юутайгаа уялдуулах уу гээд ингээд зөндөө шат шатны асуудлууд байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэлээн тийм.

**Н.Энхболд:** Ганболд гишүүнд дахиад нэг минут.

**Г.Ганболд:** Харин Ганбат дарга аа, бид нар эхлээд түүнийг чинь хармаар байх юм. Түүнийг харж байж бид нар үүнийг батлах уу, үгүй юу гэдгийг нь шийдмээр байх юм. Тэгэхгүй ингээд баахан яам, тамгын газрыг хотоос

аваачаад хол газар тавьчихдаг. Энэ чинь төрийн бөөн хүнд суртал, наашаа, цаашаа давхисан бөөн зардал чирэгдэл болсон. Ард иргэдэд төрийн байгууллагуудад, нэг яаман дээр очиж уулзах гээд Дархан руу давхидаг болох уу. Дарханаас наашаа баахан дуудагдаж давхиж ирдэг болох уу. Багануурт аваачиж тавьчихаад тэндээс дуудагдаж ирэх хэрэг болох уу. Эхлээд тэр загварыг чинь бид нар харж байж л уг нь үүнийг дэмжих үү. Эндээ тэгээд байж байх уу. Тэр гарчихлаа гээд түгжрэл хэдэн хувиар буурах юм. Тэндээс гарах энэ зардал чирэгдлүүд нь юу болох юм гэдгийг тооцоолж байж л хэдүүлээ. Тогтоол баталсны дараа араас нь өгнө гэхээр чинь энэ чинь юу ч батлах гээд байгаагаа би ч бас ойлгохгүй сууна л даа.

**Н.Энхболд:** Дэлгэрсайхан сайд.

**Б.Дэлгэрсайхан:** Ганболд гишүүний асуултад хариулъя. Тэгээд миний эрхлэх ажлын хүрээнд хот, хөдөөгийн хөгжлийн сэргэлтийн бодлогын асуудал бас явдаг. Тэгэхлээр зэрэг бид бас энэ Хөшигтийн хөндийг дагасан шинэ Зуунмод хотхоны ажлыг эхлүүлээд явж байгаа. Тэгээд ялангуяа дэд бүтэц дээр нь нэлээн анхаараад тэгээд энэ ажил энэ жил бас эхэлчих байх гэж бодож байгаа.

Тэгэхээр өөрийн чинь асууж байгаа энэ төрийн байгууллага, сая Бямбацогт сайдын хэлсэн энэ зам, тээвэр болоод МИАТ, түүнийг дагасан нисэхийн удирдах байгууллагууд Хөшигтийн хөндий рүү дагаж бас нүүх ийм боломж бололцоо нь бүрдэнэ. Тийм учраас эхний ээлжид мэдээж учир зүггүй яам, тамгын газраа бас хөдөө орон нутаг руу.

**Н.Энхболд:** Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Өглөөний мэнд хүргэе та бүхэндээ. Миний асуулт Ганболд гишүүнийхтэй нэлээн ойролцоодуу. Тэгээд та бүхэн маань энэ танилцуулгыг сайн уншсан бол анзаарсан байх. Бид нар Улсын Их Хурлаар одоогоос

22 жилийн өмнө Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа баталсан. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал ярихаар яадаг гэвэл ерөөсөө хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгана, төрийн үйлчилгээг жигд болгоно. Хамгийн гол нь төвлөрлийг сааруулна. Нөгөө утаа бууруулна гээд нэг ийм зүйл ингээд ярьдаг л даа. Тэгээд өнөөдөр та бүхэн маань Улаанбаатар хотоо харахад хүн амын төвлөрөл Улаанбаатар хотод саарсан уу. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын үр дүн энэ 20, 22 жилийн хугацаанд ер нь яаж илрэв гэдэг дээр тооцоо судалгаа хийсэн зүйл байдаг юм уу?

Эхний ээлжид сая Дэлгэрсайхан сайдын хариулж байгааг харахад юу, юугүй яамд маань нүүхгүй л гэж байна. Тэгтэл өнөөдрийн оруулж ирж байгаа танилцуулга дээр төрийн байгууллагуудыг, яамдыг энэ бүсчилж байршуулах тухай асуудал ярьж байгаа байхгүй юу. Тэгээд би яг Ганболд гишүүн шиг аль яамыг хааш нь нүүлгэх гэж байгаа юм. Тэнд ажиллаж байгаа хүмүүс нь санал нийлж байгаа юм уу? Саяхан авсан мэдээллээр бол нэг их, дээд сургуулийг хөдөө орон нутгаас гаргах гээд багш нараас санал асуулга явуулахад 60 хувь нь явж чадахгүй гэсэн байна билээ. Тэгэхээр энэ төрийн үйлчилгээний нөгөө хэвийн байдал, тасралтгүй үйл ажиллагаа чинь ямар нэгэн эрсдэлд орохгүй гэдэг тийм баталгаа байгаа юм уу. Ер нь та нар маань хаанахын ямар туршлага судлаад яагаад энэ шийдвэрийг ингээд гаргахаар болов. Мэдээж хэрэг энэ хууль дүрэмдээ нийцүүлэх гээд л явж байгаа байх. Хамгийн гол нь бид нарын өнөөдөр батлах гэж байгаа энэ тогтоол чинь амьдралд хэзээ яаж хэрэгжих юм бэ. Тооцоо судалгаа үр дүн нь хаана байна гэдгийг би нэг тодруулаад орхиё.

**Н.Энхболд:** Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр.

**Д.Эрдэнэбаяр:** Өнөөдрийн байдлаар их, дээд сургуулийн 96 хувь нь

хотод төвлөрсөн байна. Мөн худалдааны салбарын 84 хувь, бүртгэлтэй автомашины 84, хуримтлалын 77 хувь, идэвхтэй ААН-ийн 70 хувь гээд. Энэ бүгдээс үүдэлтэй гамигийн эрсдэл, утааны асуудал, түгжрэлийн асуудал 3 дахин төв замын ачаалал нэмэгдсэн зэрэг ийм үр дүнгүүд гарсан байгаа. Тэгэхээр Занданшатар даргыг Хэрэг эрхлэхийн дарга байхад 3 тулгуурт бодлого гэж гараад энэ хүрээнд эдийн засгийн бүсчлэх ажлын хэсэг гараад өнгөрсөн 7 жилийн хугацаанд 100 орчим эрдэмтэд ажилласан. 21 аймгаар явж бүгдэнгээр нь хэлэлцүүлэг хийсэн. Мөн Жайкагийн төсөлтэй хамтарч 3 жилийн судалгаа гаргасан байгаа. Ингээд яг бодитой жишээ хэлэхэд, өнөөдөр хангамжийн логистикууд бүгд Улаанбаатарт төвлөрсөн. Тэгээд эндээс үүдэлтэй бас түгжрэлийн асуудал, баруун, зүүн бүсийн ачаа тээврийн хүндрэлүүд үүсэж байгаа.

Тийм учраас бид нар өрнө, дорныг холбосон гол аймгууд дээрээ тээвэр ложистик, хуурай боомтыг байгуулах энэ чиглэлийн ААН-үүд үүнтэй холбоотой гүний гааль холбогдох тээвэр ложистикийн үйлчилгээ, үүнтэй холбоотой төрийн үйлчилгээг 7 аймаг дээр шилжүүлэх ийм судалгаа гарсан байгаа.

Ингэснээрээ Монгол улсын ачаа тээвэр хөнгөвчлөгдөж тээвэр логистикийн зардал буурах, эдийн засгийн хамгийн гол эргэлт болсон энэ зүйл бол орон нутагт мөн транзит тээвэртэй холбоотой асуудлууд, боомтын асуудлууд нэлээн гол асуудал болж гарч ирж байгаа. Бид нар бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээрээ 5 босоо тэнхлэг, нэг хэвтээ тэнхлэг үүнтэй холбоотой гол боомт хотуудын төлөвлөлтийг жишээ болгож хийсэн.

Хоёр дахь асуудал нь, боловсролын салбар дээр их, дээд сургуулиудын салбаруудыг тухайн бүсийнх нь нөөц онцлогтой нийцүүлж байгуулах асуудлыг тусгасан байгаа.

**Н.Энхболд:** Сарангэрэл гишүүн тодруулъя.

**Д.Сарангэрэл:** Би тогтоолын төслийг огтхон ч эсэргүүцээгүй. Үндсэндээ бүүр дэмжиж байгаа. Хамгийн гол нь амьдралд хэрэгжих ийм л тогтоол Байнгын хороо маань, Их Хурал маань гаргаасай гэж бодож байгаа юм. Тухайлбал зарим улс орнуудын ялангуяа урд хөршийн жишээг ингээд харж байхад хүмүүс их төвлөрдөг захуудаа төвөөсөө гаргах, хаана төвлөрөл их байна түүнийгээ саармагжуулах л үйл ажиллагаа явуулдаг юм байна. Түүнээс биш нэг яамаа тийш нь авааччихъя, нэг байгууллагаа тийш нь нүүлгэчихье гээд ингээд өм цөм шийддэггүй юм байна.

Тэгээд та нар маань сайн судлаарай. Хамгийн гол нь тавьсан зорилтдоо хүрэх нөгөө бид нарын яриад байгаа утааг бууруулах, түгжрэлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа гаргах гээд нэг том тодорхойлолт хийчихсэн байгаа шүү дээ. Энэ үр дүнд хүргэхийн тулд бодит ямар алхмуудыг бид нар хийх ёстой вэ, хаана манайхтай ижил төстэй ийм туршлага байна гэдгийг сайн судалж байж энэ шийдвэрүүдээ гаргахгүй бол ерөөсөө нэг тооцоо судалгаагүй юм оруулж ирээд, тэгээд баахан маргаан үүсгээд, тэгээд түүнийг нь баталсан батлаагүй явдаг ийм нөхцөл байдлыг.

**Н.Энхболд:** Сарангэрэл гишүүн үг хэллээ. Батсуурь гишүүн асууя.

**Ж.Батсуурь:** Өглөөний мэнд. Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох тогтоол их ойлгомжгүй тогтоол байна. 2001 он 24 жил унтаж байгаад, 2001 онд бүсчлэлээ одоо л гялайлгаад өгнө гээд маш олон зүйл ярьж байсан. Тэгээд тэндээс юу үлдсэн бэ гэхлээр Монгол Улсын газрын зургийг 3, 4 аймгаар нь хилээр нь зураад өөр өнгөөр будсан нэг зураг л үлдсэн. Өөр ерөөсөө юм энэ 24 жилд хийгдээгүй. Тэгээд энэ

тогтоолыг хараад байхад саяын Сонгуулийн хуулийг дагаж гарч байгаа бүсчилсэн аймгууд дээрээ очиж ярих яриагаа хийх үүний гарын авлага болгосон л тогтоол байна гэж харагдаж байна. Ерөөсөө маш ойлгомжтой. Жишээлбэл, Сарангэрэл гишүүний асуулт дээр өмнөх хэлэлцүүлгийг хийчихсэн гэж энэ дарга нар чинь хэлээд байна шүү дээ. Тэр хэлэлцүүлгийн үр дүнг ярилцах энэ, энэ, энэ гээд байгаа байхгүй юу. Энэ тогтоолын 2.2-т бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгох, ямар бодлогыг боловсронгуй болгох эхний бодлого нь гараагүй байна шүү дээ. Аль сургууль аль аймагт очих юм. Энэ хүмүүс асуугаад байна шүү дээ. Аль яам аль аймагт очих юм. Бодлого нь гараагүй байж байж ямар юмыг хэлэлцэх гээд байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 2001 оноос 24 жилийн 6 удаагийн сонгууль болсон байна. 6 удаагийн сонгуульд 5 удаа Ардын нам эрх барьсан. Ингээд 24 жил унтаж байгаад, сая нөхцөл байдал эвгүйтээд ирэнгүүт ялах боломжийнхоо хамгийн боломжит хувилбарыг Сонгуулийн хуулиар хийж аваад, ингээд бүсчлэл рүү очингуут ярих билээ гээд тийм болонгуут гарын авлага бэлтгэж өгч байгаад бүсчилсэн хөгжлийг ярина гээд ингээд 24 жил унтсан зүйлээ сэргээж гаргаж ирж ярьж байгаа юм.

Жишээлбэл, бүсчилнэ гээд, энэ дээр хот, хөдөөгийн ялгаа аймгийн бүс нутаг хоорондын тэгш бус эрэмбэлнэ гэж байгаа юм. Эрэмбэлсэн нь хаана байгаа юм жишээ нь. Ингээд дандаа ийм хийсвэр хоосон үгнүүд. Тэгээд үүнийг ингээд дүгнээд хараад, энэ цаасыг яг ингээд уншвал Их Хурлын хаврын чуулганаас өмнө бүсчилсэн саяын сонгуулийн тойргууд дээрээ очиход хэлэлцүүлэг хийж байгаа юмаа. Тэгтэл тэнд хариулаад байгаа дарга чинь өмнөх Занданшатар даргыг Хэрэг эрхлэх газрын дарга байхдаа бид нар хэлэлцүүлгээ хийчихсэн гээд байна шүү дээ. Тэгээд түүний үр дүн гараагүй

байхад дахиад хэлэлцүүлэг хийж форум хийж яах юм.

Тийм болохлоор би үүнийг нэг их айхтар бүсчлэн хөгжүүлээд улс орныг гялайлгах гэж байгаа зүйл гэж харагдахгүй байна. Яагаад вэ гэхлээр 24 жил хийгээгүй. Тэгээд яг сонгууль болохоос 6 сарын өмнө хамгийн сүүлийн чуулганы өмнө ийм тогтоол батлуулж авна гэдэг нь 6 сарын сонгуульд орох гэж байгаа, тойрог руугаа очих гэж байгаа Их Хурлын гишүүдийн гарын авлагыг бэлдэж өгөх гэж байна л гэж ингэж харагдаж байна.

Тэгэхээр эндээс хөгжил харагдахгүй шүү дээ. Жишээлбэл, Сүхбаатар аймагт ямар сургууль очих гэж байгаа юм. Ямар аймаг очих гэж байгаа юм. Зүүн бүс гээд заачихсан. Зүүн бүсийн төв нь аль юм. Газар нутгаар нь төвийг нь заах гээд байгаа юм уу, хүн амаар нь төвийг нь заах гээд байгаа юм уу. Эдийн засгийн хүчин чадлаар нь төвийг нь заах гээд байгаа юм уу гэсэн бодлого огт байхгүй. Тэгээд тэнд очиж хүмүүс дээр юу ярих гэж байна вэ гэхээр, маш гоё бүсчилсэн хөгжил гэсэн ийм сэдэвтэй электрон дэлгэц хулдаасан дэлгэц дээр очоод, одоо л жинхэнэ алаад өгөх гэж байна гээд. Тэгээд хүмүүс нь хөөрхий амьтан 24 жилийн өмнө та бүхнийг ингээд хөгжүүлнэ гээд ярьж байсныг чинь мартчихсан байгаа шүү дээ. Тэгэхлээр бодлогоо гаргаж ирж тавимаар байна. Тэгвэл маш ойлгомжтой. Энэ чинь бодлогогүй зүгээр л хэлэлцүүлэг хийе гэж байна шүү дээ.

**Н.Энхболд:** Дэлгэрсайхан сайд.

**Б.Дэлгэрсайхан:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. Энэ сонгуультай холбоотой асуудал биш ээ. Тийм ч учраас та өөрөө ярьдаг юм шүү дээ. 20 жилийн өмнөөс ингээд бүсчилсэн хөгжлийн бодлого анх гараад ингээд ярьсан гээд. Өнөөдөр цаг хугацааны хувьд ингэж давхцаж байгаа болохоос биш ингэж бас хамаагүй мушигж болохгүй

байх аа. Яагаад гэхээр бид энэ бүсчилсэн хөгжил бол Улаанбаатар хотын өнөөдрийн гарцаагүй зогсонги байдалд, ялангуяа түгжэрэлтэй холбоотой, дээр нь төвлөрөлтэй холбоотой асуудал үнэхээр бидний нэн тэргүүний тулгамдсан асуудал болсон учраас бид үүнийг дахиад ярихаас өөр аргагүй байдалд орж байгаа, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, аль болохоор хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангахад одоо л бид нарт бас хүн болгон үүнийгээ ойлгоод нөхцөл нь бүрдэж байна гэж харж байгаа учраас үүнийг эргэж ярих асуудал зайлиггүй болж байгаа гэдгийг хэлж байгаа юм.

Гуравдугаарт, юу ярьж байгаа юм гэхээр, та үүнийг эргэж очоод сонгогчдод ярих ийм юм бэлдэж байна гэж байна. Энэ чинь аль хэдийн олон жилийн өмнө яригдчихсан асуудал учраас тэр талаас нь харж болохгүй. Мэдээж аль болохоор Засгийн газраас энэ хөдөө, хотын ялгааг арилгах үүднээс үе шаттай арга хэмжээ авч ирж байгаа. Тухайлбал би ганцхан юм хэлье. Ялангуяа төрийн албан хаагчдын цалин мөнгөний асуудлыг хөдөө орон нутагт нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хөдөө орон нутагт ипотекийн зээлийг 3 хувь болгох Засгийн газрын шийдвэр гарсан. Мөн ипотекийн орон сууцын олголтыг Улаанбаатар хотод 80 хувь, хөдөө орон нутагт 20 байсан бол сая Улсын Их Хурлаар 50, 50 болгосон. 50 хувь тэнцвэртэй, ипотекийн зээл олгох болсон гээд ингээд олон арга хэмжээнүүдийг Засгийн газар хэрэгжүүлж байгаа гэдгийг энэ даширамд хэлье. Тийм учраас үүнийг буруу талаас нь мушигж ингэж битгий ойлгоорой гэдгийг хэлье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Тэгж худлаа яриад яах вэ дээ. Жишээлбэл, энэ 3 яамны сайд баталчихсан. Төрийн байгууллагыг

бүсчлэн байршуулах тухай гээд. Тэгээд та 24 жил ажилласан гэж байна. Ажилласан бол аль аймагт ямар сургууль очих юм, аль аймагт ямар яам очих юм, ямар ч төсөл байхгүй. Одоо энэ форумууд юу болох вэ гэхээр би мэргэн хүн шиг хэлье. Одоо тэртээ тэргүй хаврын чуулганаар би асууна л даа. Та нар очоод тэнд хүмүүст таалагдсан асуудлыг ярина. Танай энэ аймагт юу хэрэгтэй байна. За тэгье, одоо очоод бид нар сургуулийг чинь байгуулаад ирье. Шал худлаа. Тэгээд сонгуулийн дараа 25 дахь жилээсээ дахиад л унтана. Харин өнөөдөр бодитой байсан бол энэ Сарангэрэл гишүүн, Ганболд гишүүн нар асуугаад байна шүү дээ. Тэр аймагт тэр сургууль очих гэж байгаа болох уу, тэр аймагт тэр яам очих гэж байгаа болох уу, болох уу, болохгүй юу гэж ингэж асуух юм бол энэ хэлэлцүүлэг мөн. Тэгэхгүй 24 жил ярьсан, хийсэн гээд тэр цалин мөнгөнд чинь бүсчлэлтэй огт.

**Н.Энхболд:** Үг гээд бодчихъё. Гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Одоо санал хураана. Манай гишүүд анзаарсан бол энэ тогтоолын төслийн танилцуулга дээр ийм үг байгаа юм, би гишүүдийг анзаарсан байх гэж бодож байна. Засгийн газар Үндсэн хууль бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн байгууллагуудыг бүсчлэн нүүлгэн шилжүүлэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх чиглэлийг Улсын Их Хурлаас Засгийн газарт өгүүлэх зорилгоор энэ тогтоолын төслийг боловсруулсан гээд биччихсэн байгаа юм. Тэгэхээр энэ бол одоохондоо яг тодорхой зүйлүүдийг тэр аймаг тийш нь, тэрийг тэнд аваачна, энийг энд аваачна гэж ярилгүйгээр ямар ч байсан Их Хурлаасаа чиглэлээ аваад ингээд асуудлаа боловсруулаад эргээд ярья гэдэг санаатайгаар оруулж ирсэн тогтоол гэж ойлгож байна.

Тийм учраас хэдүүлээ өнөөдөр хэлэлцэх эсэхийг нь шийдэж байгаа. Хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд тухайлбал анхны хэлэлцүүлэг дээр надад

ийм санал байна л даа. Тэр бол дараагийн ээлжид. Тэгэхдээ бодож байгаа юм юу вэ гэхээр жишээ нь, 1.1 дээр ингэж байгаа юм. Төрийн байгууллагууд ингэж байгаа юм, энэ ганцхан яам, Тамгын газар, гишүүн түрүүн тэр Эдийн засгийн яамны хүний тайлбар дээр гарч байсан. Жишээ нь төрийн оролцоотой ложистикийн том төвүүд, компаниудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээг харгалзаад бүсчлээд Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн байршуулах арга хэмжээ авах гээд энэ дээр заачихсан байгаа.

Би бол нэгэнт Их Хурлаас чиглэл авах гэж байгаа бол одоо энэ гишүүд шүүмжлээд байгаа шиг хэзээ, хаана, юуг аваачихаа тодорхой яриагүй мөртөө шууд ингэж чиглэл авах нь бас бодлогогүй, тулгамдчихсан, магадгүй сүүлд нь асуудал үүсэхээр юм гарчих болов уу гэж болгоомжлоод байгаа бол хэдүүлээ хэлэлцээд анхны хэлэлцүүлгээ хийхдээ тэр үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний бодлогыг нь эхлээд боловсруулчихъя.

Дараа нь холбогдох хууль тогтоомжид нь өөрчлөлт оруулчих. Тэгээд энэ зүйлүүдээ үе шаттайгаар хэрэгжүүл гэсэн ийм агуулгатай тогтоол гаргах нь зөв болов уу гэж бодож байна. Жишээ нь, хоёрдугаар заалт дээр нь хөдөө шилжих бол тэр хүмүүсийн нийгмийн асуудлыг судалж арга хэмжээ авах шаардлагатай бол гэж байгаа юм. Шаардлага заавал гарна. Нэгэнт жишээ нь сая Сарангэрэл гишүүний үгэнд гарлаа шүү дээ. Нэг сургуулийн гэхэд 60 хувь нь явахгүй гэсэн байр суурьтай л байж байна гэж. Энд байгаа хангамж, энд байгаа боломжуудаасаа тэр болгон зүгээр л яв гэхээр явчихгүй шүү дээ.

Тэгэхээр энэ шаардлагатай бол биш шаардлага заавал гарах учраас хэдүүлээ дараа нь анхны хэлэлцүүлгээр хийхдээ, жишээ нь энэ заалтын үүнийг ингээд нүүлгүүлээд эхэл гэсэн утгаар биш, шаардлагатай бол яв, шаардлагагүй

хэрэггүй гэдэг утгаар биш энэ шаардлагатай болно, үүнийг заавал хий. Нүүлгэхийгээ эхлээд бодлогоо боловсруул. Тэгээд дараа нь тэр шаардлагатай арга хэмжээнүүдийг авчхаад, тэгээд нөгөө хүмүүстэйгээ ойлгуулж зөв тал, талаасаа бид нар ямар цэргийн дэглэмтэй улс биш чи өнөөдөр шилж гээд шилжүүлээд яваад байх боломж байхгүй шүү дээ. Маш олон нийгмийн бусад улс төрийн асуудал ч дагаж үүсэж магадгүй. Ийм утгатайгаар сүүлд нь тогтоолыг нь гаргачих нь зөв болов уу гэж бодож байна.

Тэгээд энэ тогтоолын төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. 12 гишүүн санал хураалтад орж, 7 гишүүн дэмжиж, 58.3 хувиар энэ тогтоолыг хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Сарангэрэл гишүүн танилцуулчих уу.

Дараагийн асуудалдаа орёе. Тэр ажлын хэсэг байж байгаарай. Бид нарын одоогийн оруулж байгаа асуудалтай холбоотой та нараас асуух лавлах зүйл гарч магадгүй.

Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Чуулганы дэгийн тухай хуулийн 93 дээр, Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хуульд тусгайлан заасан бусад асуудлыг хэлэлцэхдээ ялангуяа хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа ирүүлсэн бол Байнгын хороо хэлэлцэж санал дүгнэлтээ танилцуулна гэсэн заалт байгаа. Энэ төслийг Байнгын хорооноос боловсруулсан та бүхэнд танилцуулсан байгаа.

Би товчхон агуулгынх нь талаар танилцуулга хийчихье.

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх, бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийг дэмжих талаар урт болон дунд хугацааны төрийн бодлого хууль тогтоомжийг батлан бүсчилсэн хөгжлийн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж ажиллаж ирсэн.

Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үндэслэл, үзэл санаа, төрийн зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлэх зорилтуудыг тодорхойлоод, хэрэгжүүлэх үе шатыг тусган баталсан байдаг. Харамсалтай нь яг бодитой ажил энэ талаар хийгдэж чадалгүй өнөөдрийг хүрсэн. Энэ талаар ч манай гишүүд Батсуурь гишүүн нар шүүмжилж байна. Үүнтэй санал нэг байгаа. Мөн Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогод бүс, орон нутаг, нийслэл Улаанбаатар хот болон дагуул хотыг хөгжүүлэх тухай, мөн Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан шинэ сэргэлтийн бодлогод боомтын болон хот хөдөөгийн сэргэлтийн зохицуулалтыг тусгасан эдгээрийг алхам, алхмаар хэрэгжүүлээд явж байна.

Сая Их Хурлаас Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд аймгуудыг бүсчилж 7, нийслэлийг 6 тойрог болгоод Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойргийг байгуулсан. Тэгэхээр энэ дээр нэг зүйлийг дахиад тодруулаад хэлэхэд бид нар, одоо сонгуулийн тойрогт зориулж бүсчилсэн хөгжлийн тухай асуудал яриад байгаа юм биш ээ. Сая бүсчилсэн томгосон тойрог сонгуульд зориулж байгуулахдаа харин эсрэгээрээ бүсчилсэн хөгжлийнхөө асуудлыг урагшлуулах зорилтыг том суурь үндэслэл болгож ийм сонгуулийн

тогтолцоог сонгож авсан. Тэгэхээр үүнийг одоо тэгж шүүмжлээд байх нь буруу л даа. Сонгуулийн хуулиа эхлээд баталчхаад дараа араас нь бүсчилсэн үзлийн юм ярих гээд байгаа юм шиг ойлгох нь би бас тийм биш л гэж бодож байна. Яагаад гэвэл эхнээсээ бид нар бүсчилсэн хөгжлийнхөө зорилго, олон жижгээ багасгая элдэв олон юм ярьж байгаад сонгуулийн тойргоо сонгосон учраас яах ч аргагүй сонгуулийн өмнө ч бай, хойно ч бай үүнийг тодорхой хэмжээгээр 2021 оныхоо бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай ч уялдуулж ярих байх. Тэр үед бас зүгээр сууж байгаад тэр зүйлүүд гараад ирээгүй, бас л тодорхой хэмжээгээр олон талаас нь судалж байж гаргасан тийм анхны оролдлого байсан.

Тэгээд саяын тойргийнхоо асуудалтай уялдуулаад ингээд ярих хэрэг гарна. Тэр үзэл баримтлал маань 2001 онд хэдийгээр анх батлагдаж байсан ч гэсэн зорилго хэрэгжүүлэх үе шатыг нь 2001-2005, 2010 он хүртэл, 2010-аас хойших 10 жил гэсэн 3 үе шатаар тусгасан байдаг тэр үедээ.

Эндээс үүдээд Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогод тусгаж ирүүлж байгаа бүсчилсэн хөгжлийн зорилтууд түүний хэрэгжилтийг яагаад ийм байдалтай болчхов, одоо яагаад үүнийгээ сэргээж тайлбарлаж цааш нь үргэлжлүүлэх шаардлага гарч байна вэ гэдгийн талаар тайлбарлаад, иргэдийн байр суурийг сонсоод, тэгээд энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа боловсронгуй болгох сая гишүүдийн яриад байгаа яг хаагуураа яаж бүсчлэх юм, хаана нь юу байх юм гэдэг юман дээрээ иргэдээс санал авах нь зүйтэй гэсэн ийм байр суурины үүднээс энэ тогтоолын төслийг боловсруулсан.

Ингэхдээ Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93.93.1 дэх хэсэгт заасан энэ заалтыг үндэслэж боловсруулсан юм. Энэ төсөлдөө бид нар намрын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд бүсчилсэн хөгжлийн талаарх

бодлого, хууль тогтоомж яаж гарч байсан юм. Одоо тэр бодлого яаж хэрэгжсэн юм, хэрэгжсэн нь юу юм, хэрэгжээгүй нь юу юм. Анхны зорилго үзэл баримтлал нь юу байсан юм гэдгийг тайлбарлаж таниулаад, тэгээд одоо энэ сонгуулийн тойрог ч ийм боллоо. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилсан.

Тэгэхээр үүнийг шинэчилж боловсруулахтай холбогдуулаад уулзалтууд хэлэлцүүлэг зохион байгуулах, энэ гарсан саналууддаа тулгуурлаад бүсчилсэн хөгжлийн бодлогуудаа илүү боловсронгуй тодорхой болгох, энэ хүрээндээ бас бүсчлэлийг тогтоох асуудлаар эдийн засгийн форумууд зохион байгуулъя гэж санаачилга гаргаж байгаа юм. Энэ тогтоолыг боловсруулахдаа бид нар бас зөвхөн Байнгын хороон дээр сууж байгаад ярьчхаагүй. Засгийн газартай бас тодорхой хэмжээгээр санал солилцсон. Ялангуяа энэ бүсчилсэн байдлаар форум зохион байгуулъя гэдэг асуудал, үүнтэй холбогдох хөрөнгө зардал зохион байгуулалтын асуудлынх нь талаар ярьж байж энэ төслийг боловсруулсан юм.

Тэгээд явахаасаа өмнө нөгөө 2001 оноос хойш бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гараад тэр дотроос хийгдсэн юм юу байгаа юм. Ямархуу үр дүнтэй болсон юм, юу нь яагаад болоогүй юм бэ. Тэр болоогүй юмнуудаа яавал цааш нь болдог болгож үргэлжлүүлэх үү, хэрэгжүүлэх үү, илүү боловсронгуй болгох гэдэг чиглэл дээр эхлээд болоогүй шалтгаанууд урьд нь ярьсан, тохирч байсан зүйлүүдээ тайлбарлаад, тэгээд тал талаасаа ярьж байгаад энэ санал байр суурийг нь сонсъя.

Мэдээж Засгийн газрын зүгээс өөрийн боловсруулаад хийж байсан, хийж байгаа зүйл байгаа. Энэ дээр түрүүн Ганбат дарга хэлсэн. Одоо гишүүд асуувал, нэмээд тайлбарлана биз. Ингээд тал талаас нь уялдуулж байгаад ийм арга хэмжээ авъя гэсэн үзэл баримтлалаар энэ тогтоолын төслийг боловсруулсан юм.



Тогтоолынхоо төслийг та бүхэнд тараачихсан байгаа. Тэгэхээр танилцсан байх гэж бодож байна. Ингээд асуух асуулттай гишүүн байвал нэрээ өгье. Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу.

Энд 2-3-хан жижигхэн засварууд бас сүүлд нь ормоор санагдаж байна билээ. Би найруулгын чанартай жишээ нь 2 үг хасах, нэг үгийг найруулгын хувьд өөрчлөх ийм 2, 3 санал байгаа.

Тэгвэл энэ тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураачих уу? Одоо хэрэв бид нар дэмжчихвэл шууд Их Хурлаар ороод л анхны хэлэлцүүлгээрээ баталчихна шүү дээ.

Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт. 12 гишүүн санал хураалтад орж, 7 гишүүн дэмжиж, 58.3 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооноос санал дүгнэлт гарна.

Чуулганы хуралдаанд Жаргалмаа гишүүн танилцуулчих уу, Бямбацогт гишүүн.

Маргааш Үндсэн хууль байгуулагдсаны ойн өдөр болно. Хэмжээт цаазтаас Бүгд найрамдах засагт шилжинэ гэсэн ийм гоё номыг нөгөө академич Батбаяртай хамтраад бичсэн юм байна билээ. Саяхан нээлт нь болсон. Ингээд гишүүддээ Үндсэн хуулийн өдрийн баярын мэнд хүргэе. Баяраа сайхан тэмдэглэцгээгээрэй.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА